



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 07

Мөрөн

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр дүйлийн 29.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Багшийн мэргэжлийн ур чадвар, хөгжил, оролцоог дэмжин сайжруулж, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангах зорилго бүхий “Багшийн -Хөгжил” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д даалгасугай

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
_02-р сарын _03_ -ны өдрийн ___-р
тогтоолын ___-р хавсралт



“БАГШИЙН ХӨГЖИЛ” хөтөлбөр

Нэг. Нийтлэг үндэслэл

Өнөө үед нийгмийн амьдрал эрчимтэй өөрчлөгдөн хөгжихийн хирээр хүүхдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд ч хувирал өөрчлөлт гарч байна. Үүнийг багш байнга мэдэрч, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаагаа шинэчлэн өөрчилж, боловсронгуй болгох чадвартай байх нь зүйн хэрэг. Багш хүүхэд, залуусыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, нийгэмшүүлэх үүргээ амжилттай биелүүлэхийн тулд сургалтын ажлаа өнөөдрөөр хязгаарлах бус ирээдүйгээ харж олон талын мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлж байх шаардлагатай.

Нөгөө талаас багшийн ажлын байрны тасралтгүй хөгжлийг дэмжин, нийгмийн баталгааг хангах нь мэргэжлийн ур чадвартай, ажилдаа дур сонирхолтой, ёс зүйн хэм хэмжээг сахидаг хариуцсан ажилдаа эзэн болсон багш нарыг үр дүнтэй, тогтвор сууршилтай ажиллах боломжийг бүрдүүлэх давуу талтай. Багшийн хөгжлийг дэмжсэн орон нутгийн бодлого төлөвлөлт нь аймгийн боловсролын үйлчилгээний чанарт ахиц гарган, багшийн хөгжил, нийгмийн баталгааг хангана гэж үзэж байна.

“Багшийн хөгжил” хөтөлбөр нь Монгол Улсын “Боловсролын тухай хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”, “Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, “Хөгжсөн Хөвсгөл-2030”, аймгийн Засаг даргын “Хөгжлийн Хөтөч”-“Оюунлаг Хөвсгөл” дэд хөтөлбөр, аймгийн “Боловсрол, соёлын салбарын стратеги төлөвлөгөө”, “Цахим боловсрол”, “Дэлхийн Хөвсгөл” зэрэг эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа, зарчимд үндэслэсэн болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх зарчим

2.1 “Багшийн хөгжил” хөтөлбөрийн зорилго нь багшийн мэргэжлийн ур чадвар, хөгжил, оролцоог дэмжин сайжруулж, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангах замаар боловсролын чанарт ахиц гаргахад оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

2.2.1 Багшийн хөгжлийг дэмжих орон нутгийн бодлогыг тодорхойлох

2.2.2 Багш ажлын байрандаа мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх нөхцөл

боломжийг бүрдүүлэх

2.2.3 Багшийн нийгмийн баталгааг дэмжих

2.3 Хөтөлбөрийн хэрэгжүүлэх зарчим

2.3.1 Хөтөлбөр нь багш бүрийн нийгмийн хариуцлага, хөгжлийн түвшин, эрэлт, хэрэгцээ, сонирхол, боломж, итгэл үнэмшилд тулгуурлах

2.3.2 Боловсролын тухай хууль болон холбогдох бусад бодлогын баримт, бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх

2.3.3 Хөтөлбөрт тусгагдсан багшийн хөгжил, оролцоо, нийгмийн баталгааг дэмжих үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх

2.3.4 Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн жигд оролцоог хангах

2.3.5 Мэдээлэл харилцааны технологийн оновчтой, үр дүнтэй, зөв хэрэглээг ашиглах

2.3.6 Цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, хамрах хүрээ

3.1 Хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлнэ.

3.2 Хөтөлбөр нь дараах үе шатуудаар хэрэгжинэ. Үүнд:

3.2.1 Багшийн хөгжлийг дэмжих аймаг, орон нутгийн бодлого тодорхой болж, багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих орчин нөхцөл бүрдэх үе шат 2020-2021

3.2.2 Багшийн хөгжил, оролцоо сайжирч, нийгэмд эзлэх байр суурь нэмэгдэн, нийгмийн баталгаа хангагдах үе шат 2022-2023

3.3 Энэхүү хөтөлбөр нь Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн боловсролын байгууллагын багш, удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн хүрээнд үйлчилнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1 "Багшийн хөгжлийг дэмжих орон нутгийн бодлогыг тодорхойлох" зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.1.1 "Багшийн хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийг АЗДТГ, БСУГ, ГБХЗХГ, ЭМГ, сургууль, цэцэрлэг, ТББ-ийн оролцоотой байгуулна.

4.1.2 Аймгийн түвшинд мэргэжлийн хичээл бүрээр багшийн хөгжлийг дэмжин ажиллах арга зүйн зөвлөлийг бүхий шилдэг арга зүйтэй багш нар, тэргүүн туршлага бүхий ахмад багш нараар бүрдүүлнэ.

4.1.3 Сум, орон нутгийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэн багшийн хөгжлийг дэмжин ажиллах мэргэжлийн салбар зөвлөлийг байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

4.1.4 Сургууль, багшийн бие даасан байдлыг хангах, олон нийтийн оролцоот

сургууль болон хөгжих арга зүйг хөгжүүлж, багшийн хөгжилд сургуулийн зөвлөл, эцэг эхийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.5 Боловсролын байгууллага бүр (ЕБС, СӨББ) багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөлтийг гаргаж ажиллана. Багш бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөг байгууллагын багшийн хөгжлийг дэмжих төлөвлөлттэй уялдуун боловсруулах ажлыг тогтмолжуулж ахиц өөрчлөлтийг тооцно.

4.1.6 Тухайн хичээлийн жилд мэргэжлийн хичээл тус бүрээр багшийн хөгжлийн цагийг хичээлийн хуваарьт тусган оруулж, Боловсрол, соёл, урлагийн газраас www.online.khuv.mn сайтаар дамжуулан зайны сургалтыг явуулах нэгдсэн цаг, хуваарийг гаргаж бие даан хөгжих боломжийг бүрдүүлнэ.

4.1.7 Багшийн хөгжлийн сайн дурын клубуудын үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлж, шинжлэх ухаан, инноваци, хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.

4.1.8 Боловсрол соёл урлагийн газар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх багаас “Багшийн хөгжил” багшлахуй болон суралцахуйн зөвлөмж, арга зүй, туршлага, дүрэм журам, мэдээ мэдээлэл бүхий сэтгүүлийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хагас жилд нэг удаа эрхлэн гаргана.

4.2 “Багш ажлын байрандаа мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх” зорилт 2-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.2.1 Багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөгжих хэрэгцээний нэгдсэн судалгааг гаргаж, багшлах хүний нөөцийн бодлого, боловсон хүчний хэрэгцээг тодорхойлно.

4.2.2 Нэн шаардлагатай байгаа мэргэжлээр багш бэлтгэх, багшийн нөөц бүрдүүлэх чиглэлээр багш бэлтгэдэг их дээд сургуультай хамтран ажиллаж мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлж, шаардлагатай байгаа нөөцийг ханган, хүний нөөцийн журам боловсруулан мөрдөж ажиллана.

4.2.3 Гадаад хэл, мэдээлэл харилцааны технологийг ашиглан харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, цахим сургалтын www.online-khuv.mn –ийг үр дүнтэй ашиглан багш хамтдаа хөгжих нөхцөлийг сайжруулна.

4.2.4 Багш ажлын байран дээрээ мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжих боломж бүрдсэн багш хөгжлийн төвийг байгуулж, мэдээ мэдээллээр ханган, мэдээллийн сан бүрдүүлэн, баяжуулж, ном гарын авлага, цахим хичээл, хэрэглэгдэхүүн, сургалтын шинэ арга, туршлагыг түгээнэ.

- 4.2.5 Багш нарын хөгжлийг дэмжин чадваржуулах сургалтыг тэргүүн туршлага бүхий багшийн ур чадвар, арга зүйд тулгуурлан орон нутгийн болон бүс, сургуулийн түвшинд зохион байгуулж, сайн туршлага, арга зүй, технологийг цахим сүлжээнд байршуулж Боловсролын технологийн хөгжлийн санд бүртгэнэ.
 - 4.2.6 Багш нарын гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг бүхий талаар дэмжин, БНСУ-ын Тэжон хотын Со дүүрэг, Япон улсын Нийгата мужтай боловсролын салбарт хамтран ажиллах, ОХУ-ын Эрхүү хотын Улсын их сургууль зэрэг гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж багш, сурагч, оюутан солилцоо, судлаач, багш бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил боловсруулах, боловсролын болон эрдмийн зэрэг авах үйл ажиллагаа явуулан, холбогдох хууль эрх зүйн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.
 - 4.2.7 Соёл, урлаг, боловсролын чиглэлээр орон нутагт ажиллаж буй төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж харилцан суралцах, хөгжих, туршлага солилцох боломжийг бүрдүүлэн "Багш солилцоо", "Урилгатай багш", "Зочин багш" зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна.
 - 4.2.8 Багшийн ёс зүй, хандлагын эерэг өөрчлөлтийг дэмжсэн зорилтот сургалт, үйл ажиллагааг хөтөлбөр хэрэгжих хугацаанд давтамжтайгаар зохион байгуулна.
 - 4.2.9 Ахмад туршлагатай багш нар залуу багш нарыг халамжлан хүмүүжүүлэх, багшлахуйд сургах, дадлагажуулах үйл ажиллагааг тогтмол явуулна.
- 4.3 *"Багшийн нийгмийн баталгааг дэмжих"* зорилт 3-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 4.3.1 Боловсролын салбарын багш, удирдах ажилтан, ажилтнуудыг хөнгөлттэй нөхцлөөр орон сууцжуулах *"Боловсрол хотхон"* төсөл, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.
 - 4.3.2 Багш, ажилтнуудыг эрүүл мэндийн цогц үзлэг, оношлогоонд ээлж дараатай оруулж эмчилгээ сувилалд хамруулна.
 - 4.3.3 Багшийн ажлын бодит гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлж, ажлын үнэлгээг хөгжлийн хөшүүрэг болгоход чиглүүлнэ.
 - 4.3.4 Багшийн ажлыг үнэлэхдээ тухайн багшийн өөрийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн тусган хэрэгжүүлэх арга зүйг сургууль, боловсролын байгууллагад нэвтрүүлнэ.
 - 4.3.5 Мэргэжлийн ур чадвар сайтай хөгжсөн багшийг тогтвор сууршилтай

ажиллуулах асуудлыг орон нутаг, боловсролын байгууллагууд бодлогодоо тусгаж, нийгмийн баталгааг (байр, орон сууц, цалин, урамшуулал тодорхой хувиар тооцох гэх мэт) хангах замаар хэрэгжүүлнэ.

- 4.3.6 Алсагдсан сум, сургуульд ажиллаж буй багшийн орон нутгийн бүсийн нэмэгдлийг үндсэн цалингаас 5-20%-иар тооцон олгох асуудлыг шийднэ.
- 4.3.7 Багшийн үйл ажиллагаа, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ёс зүй, нэр хүндийг өргөхөд чиглэсэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг тогтмол зохион байгуулна.
- 4.3.8 Ахмад багш нарыг хөнгөлөлтэй нөхцөлөөр эмчилгээ, сувилалд хамруулах ажлыг зохион байгуулна.

Тав. Хөтөлбөр хэрэгжилтийн зохион байгуулалт

- 5.1. Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийг бодлогын удирдлагаар ханган ажиллах бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Боловсрол соёл, урлагийн газраас бүрдсэн ажлын хэсэг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-д тайлагнан дүгнүүлж ажиллана.
- 5.2. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх, боловсролын байгууллагуудын оролцоо, уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн үе шат бүрийн төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, Боловсрол, соёл, урлагийн газар, НБХ хариуцан зохион байгуулна.
- 5.3. Багш нарын хөгжих хэрэгцээ, нийгмийн баталгааг хангахтай холбоотой хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн мониторингийн судалгааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, БСУГ хамтран хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжсэнээр гарах үр дүн

- 6.1 Орон нутгийн түвшинд багшийн хөгжлийг дэмжих бодлого тодорхой болж багшийг хөгжүүлэх асуудал нь тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрчимтэй, нээлттэй, сонголт хийх боломжийг бүрдүүлсэн байна.
- 6.2 Багш өөрийгөө хөгжүүлэх хандлага бий болж мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх арга зүйн мэдлэг, арга барил, ур чадвар, үзэл бодол, харилцаа, сэтгэлгээгээ бие дааж ухамсартайгаар өөрчлөх үйл явц явагдана.
- 6.3 Багш ажилтнууд дидактийн чиглэлээр судалгааны ажил хийх арга зүйд

суралцаж, англи хэл, МХТ-ийн сургалтанд ашиглах бүх талын хөгжлийн төлөвлөлт бий болсон байна.

- 6.4 Багш ажилтнуудын нийгмийн баталгаа, хөгжлийн эрх зүйн байдалд ахиц өөрчлөлт гарч, нийт багш нарын 14,8% нь зах зээлийн үнээс хямд орон сууцаар хангагдан, нийт багш нар 100 хувь эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдсан байна.

Долоо. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ

- 7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил тутам хяналт үнэлгээ хийж биелэлтийг тооцно.
- 7.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана.
- 7.3 Хөтөлбөрийн хяналт үнэлгээнд бүх талуудыг тэгш хамруулна.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

- 8.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.
- 8.1.1 Улсын төсөв
- 8.1.2 Орон нутгийн төсөв
- 8.1.3 Олон улсын хандивлагч байгууллага (иргэд, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусламж)
- 8.1.4 Бусад эх үүсвэр

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
 02-р сарын 03-ны өдрийн 07-р
 тогтоолын 2-р хавсралт

“БАГШИЙН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллагууд *
			Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт		
1	Багшийн хөгжлийг дэмжих орон нутгийн бодлогыг тодорхойлох	Хөтөлбөр хэрэгжүүлэх баг байгуулагдана	2020	-	2023	Хөтөлбөр хэрэгжүүлэх багийн тогтвортой үйл ажиллагаа	БУМС	АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ
		Сургууль цэцэрлэгүүд мэргэжлийн зөвлөл байгуулна.	2020	-	2023	ЕБС-35, СӨББ-45	Статистикийн тоо үзүүлэлт	Сумын ЗДТГ, ЕБС, СӨББ
		Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөлтийг гаргана.	2020	ЕБС, СӨББ бүр төлөвлөлт	2023	Нэгдсэн төлөвлөлт бий болно.	Нэгдсэн мэдээ	ЕБС, СӨББ
		Багшийн хөгжлийн сайн дурын клубуудын үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлж, шинжлэх ухаан, инноваци, хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.	2020	2%	2023	Клуб, оролцооны байгууллага-30%	Жилийн ажлын тайлан	ЕБС, СӨББ

	Багш мэргэжил дээшлүүлэх, хөгжих хэрэгцээний нэгдсэн судалгаатай болно. www.online-khuv.mn –ийг үр дүнтэй ашиглан багш хамтдаа хөгжих нөхцөлийг сайжруулна.	2020	Мэргэжил тус бүрээр судалгаа -10	2023	Нэгдсэн судалгаа бий болно.	БУМС	БСУГ
2	“Багш ажлын байрандаа мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх”	2020	10%	2023	Ашиглалт -100%	Статистикийн тоо үзүүлэлт	БСУГ, ЕБС, СӨББ
	Багш төвийн ажиллагааг чанаржуулан тоог нэмэгдүүлнэ.	2020	ЕБС-60%, СӨББ-20%	2023	ЕБС-100%, СӨББ-100%	Статистикийн тоо үзүүлэлт	БСУГ, ЕБС, СӨББ
	Багш нарын хөгжлийг дэмжин чадваржуулах сургалтыг зох.байгуулна.	2020	Мэргэжил тус бүрээр сургалтын тоо	2023	Гадаад хэл, МХТ, мэргэжлийн сургалтууд-100%	БУМС	АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ
	“Боловсрол хотхон” төсөл хэрэгжүүлнэ.	2020	5,7%	2023	Орон сууцанд хамрагдах хувь-14,8%	БУМС	АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ
	Багш, ажилтнуудыг эрүүл мэндийн цогц үзлэг, оношлогоонд оруулж эмчилгээ сувилалд хамруулна	2020	38,2%	2023	Эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдалт-100%	Статистикийн тоо үзүүлэлт	АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ
3	“Багшийн нийгмийн баталгааг дэмжих”	2020	30%	2023	Нийт багш нарын 60%	Статистикийн тоо үзүүлэлт	АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ
	Багшийн ажлын бодит гүйцэтгэлд суурилсан урамшууллын	2020					

	<p>Тогтолцоог бүрдүүлнэ.</p> <p>Мэргэжлийн чадвар хөгжсөн тогтвор сууршилтай ажиглуулна.</p> <p>Багшийн ажиллагаа, мэргэжлийн ур чадвар, үйл мэдлэг, ёс зүй, нэр хүндийг өргөх</p>	<p>2020</p>	<p>-</p>	<p>2023</p>	<p>Тогтвортой ажиллаж буй багшийн тоо</p>	<p>Статистикийн үзүүлэлт</p>	<p>АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ</p>
		<p>2020</p>	<p>Зөрчлийн хувь</p>	<p>2023</p>	<p>Нэр хүндийн баталгаа-100%</p>	<p>Нэгдсэн тайлан</p>	<p>АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ</p>

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
 __02-р сарын 03_ -ны өдрийн 07-р
 тогтоолын 3-р хавсралт

“БАГШИЙН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүлээгдэж буй үр дүн	Хариуцах эзэн
1.	Багшийн хөгжлийг дэмжих аймаг, орон нутгийн бодлого тодорхой болж, багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих орчин нөхцөл бүрдэх үе шат 2019-2020	“Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийг АЗДТГ, БСУГ, сургууль, цэцэрлэг, ТББ-ийн оролцоотой байгуулна. Мэргэжлийн хичээл бүрээр багшийн хөгжлийг дэмжин ажиллах арга зүйн зөвлөлийг тэргүүн туршлага бүхий багш нараар бүрдүүлнэ. Сум, орон нутгийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэн багшийн хөгжлийг дэмжин ажиллах мэргэжлийн салбар зөвлөлийг байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана. Боловсролын байгууллага бүр багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөлтийг гаргаж ажиллана.	2020	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг байгуулагдан үйл ажиллагаа тогтворжсон байна. Аймаг, сургууль, сум орон нутгийн түвшинд мэргэжлийн хичээл бүрээр арга зүйн баг, салбар зөвлөл байгуулагдаж багшийн хөгжлийг дэмжих, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, үйл ажиллагааны чанар хүртээмж дээшилнэ. ЕБС, СӨББ бүр багшийн хөгжлийн хууль, тус хөтөлбөрт нийцүүлэн багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө боловсруулан мөрдөж үр дүнтэй ажиллана.	АЗДТГ, сумын ЗДТГ, БСУГ, ТББ БСУГ, БЕБС, СӨББ БСУГ, БЕБС, СӨББ БСУГ, БЕБС, СӨББ

		Багшийн хөгжлийн сайн дурын клубуудын үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлж, шинжлэх ухаан, инноваци, хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.	2020	Багшийн хөгжлийг сайн дурын клубууд байгуулагдаж мэргэжил ур чадвар, харилцаа хандлага, ёс зүй төлөвшиж, олон нийтийн оролцоог хангагдана.	БСУГ, БЕБС, СӨББ
		Багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөгжих хэрэгцээний нэгдсэн судалгааг гаргаж, багшлах хүний нөөцийн бодлого, боловсон хүчний хэрэгцээг тодорхойлно.	2020	Нэгдсэн судалгааны сан бүрдэж, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөлт тусгалаа олсон байна.	БСУГ
	“Багш ажлын байрандаа мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх”	Гадаад хэл, мэдээлэл харилцааны технологийг ашиглан харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, цахим сургалтын www.online-khuv.mn -ийг үр дүнтэй ашиглан багш хамтдаа хөгжих нөхцөлийг сайжруулна.	2020-2021	www.online-khuv.mn ийн хэрэглээ нэмэгдэж багш ажлын байран дээрээ мэргэжил боловсролоо дээшлүүлэх, харилцан суралцах, хамтран ажиллах боломж бүрдсэн байна.	БСУГ
		Багш ажлын байран дээрээ мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжих боломж бүрдсэн багш хөгжлийн төвийг байгуулж, мэдээ мэдээллээр ханган, мэдээлллийн сан бүрдүүлэн, баяжуулж, ном гарын авлага, цахим хичээл, хэрэглэгдэхүүн, сургалтын шинэ арга, туршлагыг түгээнэ.	2020-2021	Багш хөгжлийн төвүүдийг шинээр байгуулж сургууль, цэцэрлэг бүр багш хөгжлийн төвтэй, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах нөхцөл боломж бүрдэнэ.	БСУГ, БЕБС, СӨББ
		Багш нарын хөгжлийг дэмжин чадваржуулах сургалтыг тэргүүн туршлага бүхий багшийн ур чадвар, арга зүйд тулгуурлан орон нутгийн болон бус, сургуулийн түвшинд	2020-2022	Багшийн хөгжлийг дэмжин чадваржуулах сургалтыг мэргэжлийн хичээл бүрээр жил бүр аймаг, бүсийн хэмжээнд 2-3 удаа зохион	БСУГ, БЕБС, СӨББ

		<p>зохион байгуулж, сайн туршлага, арга зүй, технологийг цахим сүлжээнд байршуулж Боловсролын технологийн хөгжлийн санд бүртгэнэ.</p> <p>Багш нарын гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг бүхий талаар дэмжин, эрдэм шинжилгээ, судалгааны ажил боловсруулах, боловсролын болон эрдмийн зэрэг авахад холбогдох хууль эрх зүйн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Харилцан суралцах, хамтран хөгжих боломжийг бүрдүүлж “Багш солилцоо”, “Урилгатай багш” үйл ажиллагааг зохион байгуулна.</p>		<p>байгуулж нийт багш нарыг 100% хамруулсан байна. Боловсролын технологийн хөгжлийн санд хичээл тус бүрээр сайн туршлагауд бүртгэгдэнэ.</p> <p>Багшийн хөгжлийн тухай хууль, тус хөтөлбөрт зааснаар багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж магисир зэрэгтэй багш-300, тэргүүлэх-335, зөвлөх-10 багштай болно.</p> <p>“Багш солилцоо”, “Урилгатай багш” үйл ажиллагааг зохион байгуулж нийт 1250 багшид хүрч ажилласан байна.</p>	<p>БСУГ, БЕБС, СӨББ</p> <p>БСУГ, БЕБС, СӨББ</p>
3.	<p>“Багшийн нийгмийн баталгааг дэмжих”</p>	<p>“Боловсрол хотхон” төсөл, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ</p> <p>Багш, ажилтнуудыг эрүүл мэндийн цогц үзлэг, оношлогоонд оруулж эмчилгээ сувилалд хамруулна.</p>	<p>2020-2023</p> <p>2020-2022</p> <p>2020-2021</p>	<p>Орон сууцны зээлийн шаардлага хангасан багш, удирдах ажилтны нарийвчилсан судалгааг гаргаж нөхцлийг хангаж буй багш нарын 14,8% нь орон сууцтай болсон байна.</p> <p>Эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд нийт багшийн нарын 70% -ийг, хөнгөлөлтэй эмчилгээ, сувилгаанд 10% хүртэл хувийг хамруулна.</p> <p>Чанарын судалгаа, үнэлгээ, анги нийтээр хүүхдийг хүмүүжүүлж байгаа багш</p>	<p>АЙМГИЙН ИТХ, АЗДТГ, БСУГ</p> <p>АЗДТГ, БСУГ, ЕБС, СӨББ</p> <p>БСУГ, БЕБС, СӨББ</p>

	<p>бүрдүүлж, ажлын үнэлгээг хөгжлийн хөшүүрэг болгоход чиглүүлнэ</p> <p>Багшийн ажлыг үнэлэхдээ тухайн багшийн өөрийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн тусган хэрэгжүүлэх арга зүйг сургууль, боловсролын байгууллагад нэвтрүүлнэ</p> <p>Мэргэжлийн ур чадвар сайтай хөгжсөн багшийг тогтвор сууршилтай ажиллуулах асуудлыг орон нутаг, боловсролын байгууллагууд бодлогодоо тусгаж, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжүүлнэ.</p> <p>Багшийн үйл ажиллагаа, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ёс зүй, нэр хүндийг өргөхөд чиглэсэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг тогтмол зохион байгуулна.</p>	<p>2020-2023</p> <p>2020-2023</p> <p>2020-2023</p>	<p>нарын ажлын бодит гүйцэтгэл ахиц амжилтыг үнэлж нэмэгдэл урамшуулал олгох ажил хийгдэнэ.</p> <p>Багшийн ажлын байрны тодорхойлолт, өөрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт, үр дүнг тооцох, үнэлэх арга зүй хэрэгжиж тогтворжсон байна.</p> <p>Мэргэжлийн ур чадвар сайтай хөгжсөн багшийг тогтвор сууршилтай ажиллуулах асуудлыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын хүрээнд шийдэж нийгмийн баталгааг хангаж ажиллана.</p> <p>Сургууль боловсролын байгууллагууд багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах ажил эрчимжиж, үйл ажиллагааны үнэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэх ажил тогтмолжсон байна.</p>	<p>БСУГ, БЕБС, СӨББ</p> <p>ИТХ, АЗДТГ, сумын ЗДТГ, БСУГ,</p> <p>БСУГ, БЕБС, СӨББ</p>
--	--	--	---	--

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
02-р сарын _03_ны өдрийн _07_-р
тогтоолын _4_-р хавсралт

**“БАГШИЙН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хөтөлбөрийн н зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт хөрөнгийн хэмжээ,	Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр, сая төг)			
				2020 он	2021 он	2022 он	2023 он
“Багшийн хөгжлийг дэмжих орон нутгийн бодлогыг тодорхойло х”	1	“Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийг АЗДТГ, БСУГ, сургууль, цэцэрлэг, ТББ-ийн оролцоотой байгуулна.			-	-	
	2	Мэргэжлийн хичээл бүрээр багшийн хөгжлийг дэмжин ажиллах арга зүйн зөвлөлийг тэргүүн туршлага бүхий багш нараар бүрдүүлнэ.	9,0	4,0	2,0	2,0	1,0
	3	Сум, орон нутгийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэн багшийн хөгжлийг дэмжин ажиллах мэргэжлийн салбар зөвлөлийг байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	5,0	2,0	1,0	1,0	1,0
	4	Боловсролын байгууллага бүр (ЕБС, СӨББ) багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөлтийг гаргаж ажиллана.	1,0	1,0	-	-	
	5	Багшийн хөгжлийн сайн дурын клубуудын үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлж, шинжлэх ухаан, инноваци, хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.	10,0	4,0	2,0	2,0	2,0
“Багш ажлын байрандаа мэргэжил, ур чадвараа	1	Багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөгжих хэрэгцээний нэгдсэн судалгааг гаргаж, багшлах хүний нөөцийн бодлого, боловсон хүчний хэрэгцээг тодорхойлно.	2,0	2,0	-	-	

тасралтгүй хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх”	2	Гадаад хэл, мэдээлэл харилцааны технологийг ашиглан харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, цахим сургалтын www.online-khuv.mn –ийг үр дүнтэй ашиглан багш хамтдаа хөгжих нөхцөлийг сайжруулна.	24,0	6,0	6,0	6,0	6,0
	3	Багш ажлын байран дээрээ мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжих боломж бүрдсэн багш хөгжлийн төвийг байгуулж, мэдээ мэдээллээр ханган, мэдээллийн сан бүрдүүлэн, баяжуулж, ном гарын авлага, цахим хичээл, хэрэглэгдэхүүн, сургалтын шинэ арга, туршлагыг түгээнэ.	10,0	-	5,0	3,0	2,0
	4	Багш нарын хөгжлийг дэмжин чадваржуулах сургалтыг тэргүүн туршлага бүхий багшийн ур чадвар, арга зүйд тулгуурлан орон нутгийн болон бүс, сургуулийн түвшинд зохион байгуулж, сайн туршлага, арга зүй, технологийг цахим сүлжээнд байршуулж Боловсролын технологийн хөгжлийн санд бүртгэнэ.	43,0	10,0	15,0	15,0	3,0
	5	Багш нарын гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг бүхий талаар дэмжин, эрдэм шинжилгээ, судалгааны ажил боловсруулах, боловсролын болон эрдмийн зэрэг авахад холбогдох хууль эрх зүйн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.	20,0	5,0	5,0	5,0	5,0
	6	Харилцан суралцах, хамтран хөгжих боломжийг бүрдүүлж “Багш солилцоо”, “Урилгатай багш” үйл ажиллагааг зохион байгуулна.	12,0	3,0	3,0	3,0	3,0
	“Багшийн нийгмийн баталгааг дэмжих”	1	“Боловсрол хотхон” төсөл, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ	4 тэрбу м		4 тэрбу м	
2		Багш, ажилтнуудыг эрүүл мэндийн цогц үзлэг,	15,0	5,0	4,0	4,0	2,0

		оношлогоонд оруулж эмчилгээ сувилалд хамруулна.					
	3	Багшийн ажлын бодит гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлж, ажлын үнэлгээг хөгжлийн хөшүүрэг болгоход чиглүүлнэ	7,0	1,0	2,0	2,0	2,0
	4	Багшийн ажлыг үнэлэхдээ тухайн багшийн өөрийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн тусган хэрэгжүүлэх арга зүйг сургууль, боловсролын байгууллагад нэвтрүүлнэ	5,0	1,0	2,0	1,0	1,0
	5	Мэргэжлийн ур чадвар сайтай хөгжсөн багшийг тогтвор сууршилтай ажиллуулах асуудлыг орон нутаг, боловсролын байгууллагууд бодлогод тусгаж, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжүүлнэ.	12,0	2,0	4,0	4,0	2,0
	6	Багшийн үйл ажиллагаа, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ёс зүй, нэр хүндийг өргөхөд чиглэсэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг тогтмол зохион байгуулна.	4,0	1,0	1,0	1,0	1,0
НИЙТ САНХҮҮЖИЛТ			179,0				
Үүнээс:	2020 он			47,0			
	2021 он				52,0		
	2022 он					49,0	
	2023 он						31,0
Улсын төсөв -30%			53,7				
Орон нутгийн төсөв-70%			125,3				
Хувийн хөрөнгө оруулалт							